# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН УВС АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Г.ХИШИГДЭЛГЭРИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “ХУУЛЬ ТОГТООМЖ, БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛТ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД” | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ №1.1.<br>Иргэн, аж ахуй нэгж байгууллагад Монгол Улсын виз, бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээллийг утсаар болон биечлэн үнэн зөв, шуурхай хүргэх. | Зөвлөгөө, мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо; | 100 | Үзүүлж буй үйлчилгээний талаар үнэн зөв зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | Иргэн ААНБ-аас ирүүлсэн өргөдөл хүсэлт-0<br>Иргэн ААНБ-аас ирүүлсэн гомдол-0<br>Цахим бүртгэлийн талаар – 30<br>Виз оршин суухын талаар - 10<br>Тайлант хугацаанд визийн зөвшөөрөлийн чиглэлээр 80 аж ахуйн нэгжээс ирүүлсэн, 21 орны нийт 191 иргэний визийн зөвшөөрөл хүссэн хүсэлт гаргасан ба хүсэлтийг ангиллавал С1 ангиллын 80 хүн, С2 ангиллын 3 хүн, С3 ангиллын 7 хүн, С6 ангиллын 20 хүн, С11 ангиллын 1 хүн, К1 ангиллын 88 хүн болно, цуцалсан К1 ангиллын 36 хүн, С1 ангиллын 2 хүн, К2 ангиллын 32 хүн болно.<br>2/ Уригчтай виз шийдвэрлэн олгох 10 аж ахуйн нэгжийн С6 болон С1 ангиллын 2 орны 4, К1 ангилал 2 нийт 1 орны 5 иргэний визийг шалган олгосон. К4 ангиллын 1, К1 ангиллын цуцалсан 1, С1 ангиллын цуцалсан 1 болно.<br>3/ Цахим виз К2 3 орны 10, К6 1 орны 7 олгосон. | 2025.01.02<br>2025.05.31 | 89% |
| ХОЁР. “ГАДААДЫН ИРЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛИЙН ДАГУУ АЙМАГ, ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ГАДААДЫН ИРГЭНД ХЯНАЛТ ТАВИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 2 | Арга хэмжээ №2.1.<br>Аймаг орон нутагт оршин суугч гадаадын иргэний бүртгэлийг хөтөлж, хяналт тавих | Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сайжирсан | 100 | Гадаадын иргэний хувийн хэрэгт тавигдах шаардлагыг | Тайлант хугацаанд Завхан аймгийн хэмжээнд 6 орны 214 иргэд оршин сууж хөдөлмөр эрхэлж байна. Гадаад иргэдийн бүртгэлийг хөтөлж объектын судалгаанд | 2025.01.02 | ~~7~~86% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байх | | ханган ажиллана. | баяжилтыг хийж ажиллаж байна. | 2025.05.31 | |
| 3 | Арга хэмжээ №2.2.<br>Батлагдсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах | Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сайжирсан байх | | Хяналт шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулахад оролцож, зөрчил гаргасан гадаадын иргэдийг тухай бүр олж илрүүлэх, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлсэн байна. | Тайлант хугацаанд:<br>Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2025.03.12-ны өдрийн 1-05/04 дугаар удирдамж Баруун бүс дэх газрын даргын 2025.03.20-ны өдрийн ББ-2025/14-01 дугаар удирдамжийн дагуу 2025.04.07-ны өдөр Улиастай сумын нутаг дэвсгэрт боловсролын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын 3 иргэд хамрагдсан бөгөөд гарсан зөрчилгүй болно. 2025.04.18-19-ний өдрийн хооронд Завхан аймгийн Улиастай сум болон Тосонцэнгэл сумын нутаг дэвсгэрт баригдаж байгаа дулааны цахилгаан станцын БНХАУ-ын иргэд хамрагдсан.<br>Монгол Улсад хувийн бусад зорилгоор оршин сууж байгаа АНУ-ын 2 иргэд хамрагдсан.<br>Улиастай сумын нутаг дэвсгэрт боловсролын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа АНУ-ын 3 иргэд хамрагдсан бөгөөд гарсан зөрчилгүй байсан болно.<br>Завхан аймгийн Алдархаан сум Донойн хөндий Алдархаан Цагаанхайрхан чиглэлийн 40 км замын ажлыг хийж гүйцэтгэх “Жунзианг интернэйшнл групп инженеринг ХХК”-ийн БНХАУ-ын 12 иргэд хамрагдсан бөгөөд Монгол Улсад 2025-04-30-ны өдөр Замын –Үүд авто замын боомтоор ирсэн, Завхан аймгийн Алдархаан суманд 2025-05-02-ны өдөр ирсэн. Паспорт баримт бичигтэй байсан. Хуульд заасан хугацаанд оршин суух үнэмлэхээ авах тухай зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | | 81% |
| 4 | Арга хэмжээ №2.3.<br>Хилийн боомт, орон нутагт зорчих гадаадын иргэний баримт бичигт үзлэг шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд | Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сайжирсан | | Хяналт тавьсан гадаад иргэдийн тоо<br>-Буцаасан гадаад иргэдийн | Тайлант хугацаанд Арцсуурь авто замын боомтод Орон чиглэлд- 1699<br>Гарах чиглэд- 1593<br>Нийт- 3292 гадаад иргэд зорчсон. | | 76% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тэмдэглэл хийж баталгаа гаргуулах, улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаах арга хэмжээ авах | байх<br>Хяналт тавьсан гадаад иргэдийн тоо<br>-Буцаасан гадаад иргэдийн тоо | | тоо | | | |
| ГУРАВ. ЗӨРЧИЛ ГАРСАН УРИГЧ, ГАДААДЫН ИРГЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЗӨРЧЛИЙН ХУУЛИЙН ДАГУУ ШИЙДВЭРЛЭХ | | | | | | | |
| 5 | Арга хэмжээ №3.1.<br>Гадаадын иргэний эрх зүйн байдлын болон Зөрчлийн тухай хууль, тогтоомж зөрчсөн уригч, иргэн, байгууллагад шийтгэл оногдуулах Хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу зөрчил гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай дүгнэлт үйлдэх, албадан гаргах ажиллагаа явуулах | Зөрчил гаргасан хуулийн этгээдийн үйлдсэн зөрчил нотлогдсон, хуулийн дагуу шийтгэл оногдуулсан, зөрчлийн материал прокурорт хянагдсан байх Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалт сайжирсан байх | 100 | Орон нутагт оршин сууж буй гадаадын иргэдийн бүртгэл судалгааг гаргаж ажилласан байна. | Тайлант хугацаанд гадаадын иргэний эрх зүйн байдлын болон Зөрчлийн тухай хууль, тогтоомж зөрчсөн уригч, иргэн, байгууллагад шийтгэл оногдуулах Хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу зөрчил гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай дүгнэлт үйлдэх, албадан гаргах зэрэг ажиллагаа явуулаагүй болон. | 2025.01.02<br>2025.05.31 | Үнэлэх боломжгүй |
| 6 | Арга хэмжээ №3.2.<br>Орон нутаг дахь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, бүртгэл хөтлөн объектын судалгааны программд оруулж хэвших, сар бүрийн хяналт шалгалтын мэдээнд тусгах, Объектын судалгааг тогтмол хийж, тухайн орон нутагт оршин суугаа гадаадын иргэний тоо, мэдээллийг сар бүр хүргүүлэх | Улирал, хагас, бүтэн жилээр тайлагнасан мэдээний тоо | 100 | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуула ажилласан байна. | Завхан аймгийн хэмжээнд гадаадын иргэн хөдөлмөр эрхэлдэг 4 аж ахуйн, нэгж байгууллагын обьектийн судалгаанд шинээр баяжилт хийж ажиллсан. | 2025.01.02<br>2025.05.31 | 77% |
| 7 | Арга хэмжээ №3.3.<br>Хилийн боомт, орон нутагт | Хяналт, шалгалтын үйл | 100 | Монгол Улсын Улсын хил | Тайлангийн хугацаанд: Баруун бүс дэх газрын даргын өгсөн чиглэлийн дагуу | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зорчих гадаадын иргэний баримт бичигт үзлэг шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд тэмдэглэл хийж баталгаа гаргуулах, улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаах арга хэмжээ авах | ажиллагаа сайжирсан байх | | нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн гадаадын иргэнийг Монгол Улсын хил нэвтрэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавьсан байна. | 2025.03.12-2025.04.07-ны өдрийг дуустал Арцсуурь авто замын боомтод үүрэг гүйцэтгэн ажилласан.<br>Арцсуурь авто замын боомтод албан үүрэг гүйцэтгэж хилээр зорчиж буй гадаадын иргэдийн баримт бичигт үзлэг шалгалт хийж ажиллав. Үүрэг гүцэтгэх хугацаанд хил орчмын үнэмлэхээр зорчигч зорчоогүй болно. Тус боомтоор Монгол Улсаас албадан гаргасан, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэд нэвтрээгүй болно.<br>Тайлант хугацаанд Арцсуурь авто замын боомтоор:<br>Орох чиглэлд- 1699<br>Гарах чиглэд- 1593<br>Нийт- 3292 гадаад иргэд зорчсон бөгөөд виз болон оршин суух журам зөрчөөгүй гарсан зөрчилгүй байсан болно.<br>Орох чиглэлд: Хоригтой болон албадан гаргасан иргэдийн нэрсийн жагсаалтад зарим гадаадын иргэд дээр тулгалт хийж ажилласан. Түр ирэгч гадаадийн иргэний Монгол улсад байх хугацааг 1 удаа 30 хүртэл хоногоор сунгах талаар 11 /ОХУ иргэнд мэдээ мэдээлэл боршур тараасан/ гадаад болон дотоод иргэдэд биечлэн болон утсаар мэдээлэл өгч ажилласан. | 2024.01.02<br>2024.11.29 | 83% |
| ДӨРӨВ. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ 4.1.<br>ТАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний виз, зөвшөөрлийн ажлын төлөвлөлт, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, албан тушаалтанд хүргүүлэх | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр тайлагнасан тоо | 100 | ТЖАХ-ийн 2025 оны гүйтөлөвлөгөө гарган батлуулах, гүйцэтгэлийн тайланг улирал хагас жилээр гаргаж, холбогдох албан тушаалтанд | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж хэлтсийн даргаар батлуулан ажиллав,<br>2025 оны 1 дүгээр улирлын ажлын үр дүнгийн тайлан, 01, 02 ,03 ,04 ,05 дугаар саруудын хийж гүйцэтгэсэн ажлын тайлан гаргаж хэлтсийн даргад цаг тухай бүрд өгч ажилласан. | 2025.01.02<br>2025.05.31 | 91% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүгнүүлэн ажилласан байна. | | | |
| 9 | Арга хэмжээ 4.2.<br>Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжтой холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд түгээх | Түгээсэн мэдээллийн тоо; Мэдээлэл түгээсэн цахим хуудасны тоо | 100 | Холбогдох албан тушаалтанд цаг хугацаанд нь гаргаж өгсөн байна. | Тайлант хугацаанд:<br>Удирдах албан тушаалтанд илтгэх хуудас -2 удаа<br>Төлөвлөгөө -1 удаа<br>Сар бүрийн хийсэн ажлын тайлан- 5 удаа улиралын тайлан-1 удаа гаргаж Баруун бүс дэх газрын дарга болон Увс аймаг дахь хэлтсийн даргад тухай бүрд нь цахимаар хүргүүлэн ажилласан.<br>Завхан аймгийн прокурорын газраас ирүүлсэн албан бичигт хариу илгээж ажилласан /1 удаа/<br>Сар бүрийн байгууллагын цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг өөрийн цахим хуудсаар болон аймаг орон нутийн цахим сүлжээнд давхардсан тоогоор 180 удаа түгээн ажилласан. | 2025.01.02<br>2025.05.31 | 74%/6 |
| 10 | Арга хэмжээ 4.3.<br>Албаны үйл ажиллагааны чиглэлээр холбогдох судалгаа, илтгэх хуудас, танилцуулга, төлөвлөгөө тайланг гарган, Газрын холбогдох нэгж, удирдлагад мэдээлэх рга хэмжээ | Боловсруулсан баримт бичгийн тоо | 100 | Үүрэг даалгаврыг хуульд тогтоомжийн дагуу биелүүлсэн байна. | Баруун бүс дэх газрын даргын шилжүүлж ирүүлсэн Увс аймгийн цагдаагийн газрын албан бичигт edoc.mojha.gov.mn системээр хариуг нь боловсруулан ажилласан.<br>Тайлант хугацаанд ББГ-ын даргад илтгэх хуудас – 1<br>Хэлтсийн цахим хуралд-2 удаа хамрагдсан.<br>Сарын тайлан-3 удаа хэлтсийн даргад өгөв.<br>Арцсуурь боомтын өдөр тутмын мэдээ болон ББГ-ын боомтуудын мэдээг 7 удаа нэгтгэж хүргүүлсэн. | 2025.01.02<br>2025.05.31 | 85%/6 |
| 11 | Арга хэмжээ 4.4.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх | Өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлсэн тухайгаа тухайн албан тушаалтанд танилцуулж, дүгнүүлсэн байх | 100 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайнд биелүүлсэн байх. | Баруун бүс дэх газрын даргын баталсан “Хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийн дагуу” 2025.02.28-2025.03.05-ны өдрийн Цагаан сарын баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэж тогтоосон цагуудад тухайн өдрийн жижүүртэй холбогдож нөхцөл байдлын мэдээг өгч ажилласан.<br>Баруун бүс дэх газрын даргын өгсөн чиглэлийн дагуу 2025.03.12-ны өдрөөс 2025 оны 04 сарын 07 нь хүртэл Арцсуурь авто | 2025.01.02<br>2025.05.31 | 81%/6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | замын боомтод ажиллав.<br>Газрын даргын өгсөн чиглэлийн дагуу Завхан аймаг оршин сууж хөдөлмөр эрхэлж байгаа 6 орны 182 иргэдийн оршин суух хугацааг программаас шүүж тодруулсан.<br>ББГ-ын даргын албан бичиг Гадаадын иргэдийн 48 цагийн бүртгэлийн талаар Завхан аймгийн хэмжээнд байгаа жуулчны бааз, рашаан сувилал, буудлуудад мэдээлэл өгч албан бичиг хүргүүлэн танилцуулан ажилласан.<br>Арцсуурь авто замын боомтод 2 алба хаагчийн амьдрах байр бариулахаар албаны газар авах ажлыг эхлүүлэн аймаг орон нутгийн Засаг даргатай уулзаж танилцуулж 2,4 га газрыг Байгууллагын нэр дээр кадастрийн зураг гаргуулан шийдвэрлүүлэх шатандаа явж байна | | |
| 12 | Арга хэмжээ 4.5.<br>Аймаг орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас болон байгууллагын хэмжээнд зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд оролцох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах | Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байх | 100 | Байгууллага болон орон нутгаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон байна. | Өөрийн хариуцсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.<br>Аймаг орон нутгийн зүгээс бүх нийтийг хамарсан цэвэрлэгээнд Улсын бүртгэлийн хэлтэс, Стандарт хэмжил зүйн газрын хамт олонтой 2 удаа хамрагдсан. Завхан аймгийн прокурорын газраас зохион байгуулсан ЗШШ эрх бүхий албан тушаалтнуудад орсон зөвлөгөөнд хамрагдсан.<br>Завхан аймгийн прокурорын газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2017.07.01-өдрөөс 2025.03.31-ний өдрийн байдлаар Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр эрх бүхий албан тушаалтнаас оногдуулж шийдвэрлэсэн хэрэг материалын хүлээлгэн өгч шалгуулсан. | 2025.01.02<br>2025.05.31 | 78% |
| 13 | Арга хэмжээ 4.6.<br>Байгуллагын эд хөрөнгийн тооллогыг хийж, албан | Байгууллагын эд хөрөнгө албан хэрэгцээнд ашиглаж буй эд | 100 | Эд хөрөнгө техник хэрэгсэлд | Албанд хэрэглэгдэж байгаа техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаж байна. | 2025.01.02 | 76% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгцээнд ашиглаж буй эд хогшил, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж, засаж сайжруулах арга хэмжээ авах | хогшил, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих | | | | 2025.05.31 | |
| 14 | Арга хэмжээ 4.7.<br>Ажлын чиг үүргийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, удирдлагад танилцуулж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажиллах | Иргэн аж ахуй нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх | 100 | Ирүүлсэн өргөдөл, гомдлийн бүсийн захиргаанд шилжүүлж ажиллах. | Тайлант хугацаанд иргэн болон аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл болон гомдол, хүсэлт ирүүлээгүй болно. Гадаадын иргэний 48 цагийн бүртгэлийн талаар Завхан аймгийн хэмжээнд үлй ажиллагаа явуулж байгаа жуулчны газар, буудал, рашааны сувилал зэрэг 20 газарт зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 2025.01.02<br>2025.05.31 | 74% |
| 15 | Арга хэмжээ 4.8.<br>Албаны өрөөнд тохижилт хийх. /Самбар шинээр хийх, цэцэг тарих, ус буцалгагч авах гм/ | Тохижилт, засварын байдал, тохь тухтай орчин бүрдсэн эсэх, | | | Сар бүр нэг бүтээлч ажил санаачлан хийх ажлын хүрээнд:<br>1 дүгээр сард албаны өрөөнд хогийн сав авсан.<br>2 дугаар сард Баруун бүс дэх газрын 2 давхарын хананд газрын зураг хамт олноороо нийлж хийх ажилд оролцсон.<br>3 дугаар сард Баруун бүс дэх газраараа биеийн тамрын хувцас захиалж хийлгэн жигдэрсэн.<br>4 дүгээр сард Боршоо авто замын боомтын амьдрах байранд "газан плитк" хэлтсийн албан хаагч нар мөнгө нийлүүлэн авсан.<br>5 дугаар сард Баруун бүс дэх газрын гадна талбайд нийт алба хаагчтай хамтран мод тарих ажлын хүрээнд явагдсан. | | 84% |

## Хоёр. мэдлэг, чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Эхний хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | Арга хэмжээ №1.1. | Сургалтанд | 100 | - | Уншиж танилцсан үүрэг, зөвлөмж, дотоод албан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Шинээр батлагдсан эрх зүйн актуудыг судлах, төрийн болон төрийн бус байгууллагуудын зарласан сургалтуудад хамрагдах | хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. | | | бичиг-13<br>Ерөнхий газраас зохион байгуулсан Мэдээллийн цагт-10 удаа хамрагдсан.<br>Баруун бүс дэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан тоо: 10 удаагийн сургалтад цахимаар хамрагдсан.<br>Баруун бүс дэх газар болон хэлтсийн цахим хуралд- 8 удаа хамрагдсан.<br>Аймаг орон нутгаас зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан тоо: 1 удаа танхимаар.<br>Удирдлагын академийн дунд шатны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан.<br>Судалгаа болон санал асуулгад хамрагдсан тоо- 13<br>2025.01.02-2025.05.31-ний өдрүүдэд Байгууллагын цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг өөрийн цахим хуудас болон Завхан аймгийн 11 мэдээллийн цахим хуудсаар 24 төрлийн мэдээ мэдээллийг давхардсан тоогоор нийт 190 удаа түгээн мэдээлэн хуваалцсан. | 2025.01.02<br>2025.05.31 | 79% |
| 2 | Арга хэмжээ №1.2. Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх | Сургалтанд хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. | 100 | - | Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж сертифекат авсан. | 2025.01.02<br>2025.05.31 | 80% |

ТАЙЛАН ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ (signature) Г.ХИШИГДЭЛГЭР

2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН УВС АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ХИШИГДЭЛГЭРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. “ХУУЛЬ ТОГТООМЖ, БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛТ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД” | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ №1.1.<br>Иргэн, аж ахуй нэгж байгууллагад Монгол Улсын виз, бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө мэдээллийг утсаар болон биечлэн үнэн зөв, шуурхай хүргэх. | Зөвлөгөө, мэдээллийн хэлбэр, иргэнд үйлчилгээ хүргэсэн тоо; | 100 | Үзүүлж буй үйлчилгээний талаар үнэн зөв зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | Иргэн ААНБ-аас ирүүлсэн өргөдөл хүсэлт-0<br>Иргэн ААНБ-аас ирүүлсэн гомдол-2<br>Цахим бүртгэлийн талаар 26<br>Виз оршин суухын талаар 20<br>Түр ирэгч гадаадийн иргэний Монгол улсад байх хугацааг 1 удаа 30 хүртэл хоногоор сунгах талаар 11 / ОХУ иргэнд мэдээ мэдэлэл боршур тараасан/<br>гадаад болон дотоод иргэдэд биечлэн болон утсаар мэдээлэл өгч ажилласан. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| ХОЁР. “МОНГОЛ УЛСАД АЛБАН БОЛОН ХУВИЙН ХЭРГЭЭР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 2 | Арга хэмжээ №2.1.<br>Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэнд холбогдох төрийн байгууллагын саналыг үндэслэн тус улсад оршин суух зөвшөөрөл олгох, сунгах хүсэлт, баримт бичгийг хянан шалгаж, хүлээн авч үйлчилгээний талаар зөвлөгөө өгөх | Холбогдох хуулийн дагуу төрийн үйлчилгээг хуулийн хугацаанд хүргэх | 100 | Үзүүлж буй үйлчилгээний талаар үнэн зөв зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | Тайлант хугацаанд Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, аж ахуй нэгж байгууллагад оршин суух зөвшөөрлийг цахимаар мэдүүлэх аргачлалын талаар 1 иргэнд, оршин суух зөвшөөрөл хугацаа сунгуулах талаар 5 иргэнд утсаар зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| ГУРАВ. “ГАДААДЫН ИРЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛИЙН ДАГУУ АЙМАГ, ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ГАДААДЫН ИРГЭНД ХЯНАЛТ ТАВИХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ №3.1.<br>Аймаг орон нутагт оршин суугч гадаадын иргэний бүртгэлийг хөтөлж, хяналт тавих | Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сайжирсан байх | 100 | Орон нутагт оршин сууж буй гадаадын иргэдийн бүртгэл судалгааг гаргаж ажилласан байна. | Завхан аймгийн хэмжээнд 6 орны 168 гадаад иргэд оршин сууж хөдөлмөр эрхэлж байна. Гадаад иргэдийн бүртгэлийг хөтөлж хяналт шалгалтын нэгдсэн сан, болон объектын судалгаанд баяжилтыг хийж ажилласан.<br>Байгууллагын үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан аймгийн хэмжээнд амралт сувилалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй /амралтын газар-2, жуулчны бааз-21, зочид буудал- 5, дэн буудал-33, сувилалын газар- 5/ байгууллагуудын судалгаа мэдээллийн шинэчлэн гаргав. | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Завхан аймгийн Тэс сумандхоёрдмол харьяалалтай иргэдийн мэдээллийг баруун бүс дэх газарт хүргүүлэн ажилласан. | | |
| 4 | Арга хэмжээ №3.2.<br>Хяналт шалгалтыг тухайн харьяалах бүс нутагт холбогдох албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийжгүйцэтгэх | Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сайжирсан байх | 100 | Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуула ажилласан байна. | Тайлант хугацаанд:<br>Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1-05/08 дугаарт, 2024 оны 07 дугаар сарын 22 өдрийн 1-05/11 дугаарт, Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн ББ-2024/14-01 дугаарт, 2024 оны 10 дугаар сарын 25 өдрийн ББ-2024/14-07 дугаарт, 2024 оны 11 дүгээр сарын 19 өдрийн ББ-2024/14-09 дугаарт удирдамжуудаар 5 удаа зохион байгуулсан.<br>Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 02 өдрийн ББ-2024/14-04 дугаарт, 2024 оны 10 дугаар сарын 18 өдрийн ББ-2024/14-08 дугаарт, 2024 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн ББ-2024/14-08 дугаарт удирдамжаар 3 удаа<br>Нийт 8 удаагийн шалгалтад 6 орны давхардсан тоогоор 5 аж ахуй нэгж байгууллагад ажиллаж хөдөлмөрлөж буй гадаадын 378 иргэн хамрагдсан байна. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 5 | Арга хэмжээ №3.3.<br>Хилийн боомт, орон нутагт зорчих гадаадын иргэний баримт бичигт үзлэг шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд тэмдэглэл хийж баталгаа гаргуулах, улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаах арга хэмжээ авах | Хяналт, шалгалтын үйл ажиллагаа сайжирсан байх | 100 | Монгол Улсын Улсын хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн гадаадын иргэнийг Монгол Улсын хил нэвтрэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавьсан байна. | Тайлангийн хугацаанд:Бүсийн газрын даргын<br>1. 2024.04.05-2024.04.27-ны өдрийг дуус-тал Арцсуурь авто замын боомтод үүрэг<br>2. Баруун бүс дэх газрын даргын 2024.06.20-ны өдрийн А/05тушаалын дагуу 3 дугаар улиралд боомтод ажиллах хуваарийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 15-ны өдрөөс 2024.08.27 өдрийг дуустал Арцсуурь авто замын боомтод албан үүргийг гүйцэтгэн ажилласан.<br>3. Баруун бүс дэх газрын даргын өгсөн чиглэлийн дагуу Арцсуурь авто замын боомтод 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2024,10-29-ний өдрийг дуустал ажилласан.<br>Арцсуурь авто замын боомтод албан үүрэг гүйцэтгэж хилээр зорчиж буй гадаадын иргэдийн баримт бичигт үзлэг шалгалт хийж ажиллав. Үүрэг гүцэтгэх хугацаанд хил орчмын үнэмлэхээр зорчигч зорчоогүй болно. Тус боомтоор Монгол | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсаас албадан гаргасан, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэд нэвтрээгүй болно.<br>Тайлант хугацаанд Арцсуурь авто замын боомтоор:<br>Орох чиглэлд- 4494<br>Гарах чиглэд- 4298<br>Нийт- 8792 гадаад иргэд зорчсон бөгөөд виз болон оршин суух журам зөрчөөгүй гарсан зөрчилгүй байсан болно. | | |
| ДӨРӨВ. ЗӨРЧИЛ ГАРСАН УРИГЧ, ГАДААДЫН ИРЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЗӨРЧЛИЙН ХУУЛИЙН ДАГУУ ШИЙДВЭРЛЭХ | | | | | | | |
| 6 | Арга хэмжээ №4.1.<br>Гадаадын иргэний эрх зүйн байдлын болон Зөрчлийн тухай хууль, тогтоомж зөрчсөн уригч, иргэн, байгууллагад шийтгэл оногдуулах Хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу зөрчил гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай дүгнэлт үйлдэх, албадан гаргах ажиллагаа явуулах | Зөрчил гаргасан хуулийн этгээдийн үйлдсэн зөрчил нотлогдсон, хуулийн дагуу шийтгэл оногдуулсан, зөрчлийн материал прокурорт хянагдсан байх Гадаадын иргэдэд тавих хяналт шалгалт сайжирсан байх | 100 | Хууль тогтоомжид заасан үндэслэлээр шийтгэл оногдуулсан байна. | Тайлант хугацаанд:<br>2024 оны 05 дугаар сарын 09-10-ны өдөр Завхан аймгаас БНАвстри улсын нэр бүхий 2 иргэдийг Монгол Улсаас албадан гаргах ажиллагааны дагуу хуяглан хүргэх ажлыг Увс аймаг дахь хэлтсийн дарга Х.Адъяа Завхан аймгийн цагдаагийн газрын хэв журмын тасгийн Захиргааны тасгийн цагдаа жолооч ахлах ахлагч [illegible], Завхан аймаг дахь тагнуулын хэлтсийн ажилтан Б.Энхбат нартай хамтарч ажилласан. Зөрчил шалган шийдвэрлэх газрын Хяналтын улсын ахлах байцаагч, Баруун бүс дэх газрын дарга болон хяналтын улсын ахлах байцаагч нараас чиглэл авч ажиллан хуялан хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан.<br>2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 5 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 3 удаа нийт 8 удаагийн хяналт шалгалтаар Монгол Улсад ирсэн зорилгоос өөр үйл ажиллагаа явуулж зөрчил гаргасан БНХАУ-ын 14 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5-д заасныар торгох шийтгэл оногдуулав. БНХАУ-ын 14 иргэнд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.7, Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4.10 дахь заалтад заасныар үндэслэлээр Монгол Улсаас албадан гаргах тухай байцаагчийн ББГ-15/026-03 дугаарт, ББГ-15/026-06 дугаарт дүгнэлтүүдийг үйлдэж БНХАУ-ын 14 иргэнийг Монгол Улсаас албадан гаргав.<br>2024 оны 07 дугаар сарын 15-ны өдөр | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2024.07.09-ний өдрийн А/277 дугаар тушаалыг үндэслэн БНХАУ-ын 8 иргэнийг Чингис хаан Олон улсын боомтоор Улаанбаатар-Бээжин чиглэлийн MR-801 дугаарын олон улсын хуваарьт нислэгээр Монгол Улсаас албадан гаргах ажлын зохион байгуулан ажилласан.<br>Шалгалтад хамрагдсан БНХАУ-ын иргэн Xiong Hongchuan нь Монгол Улсад байх визийн хугацааг хэтрүүлсэн нь тогтоогдсон тул 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Зөрчлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-3.3-д заасны дагуу хэтрүүлсэн хоног тутамд 280 нэгж буюу 280,000 төгрөгөөр торгох шийтгэлийг оногдуулсан.<br>Завхан аймгийн прокурорын газарт болон Тосонцэнгэл сум дундын прокурорын газрын хяналтын прокурорт зөрчлийн материалын хянуулж ажилласан. | | |
| **ТАВ. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 7 | Арга хэмжээ 5.1.<br>ТАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний виз, зөвшөөрлийн ажлын төлөвлөлт, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж, албан тушаалтанд хүргүүлэх | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр тайлагнасан тоо | 100 | 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган батлуулах, сар, улирлын гүйцэтгэлийн тайлан гаргаж, холбогдох албан тушаалтанд хүргүүлэн, ажлаа дүгнүүлэн ажилласан байна. | Төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж хэлтсийн даргаар батлуулан ажиллав,<br>2024 оны 1, 3-р улирлын ажлын үр дүнгийн тайлан, сар бүрийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлан гаргаж хэлтсийн даргад цаг тухай бүрд өгч ажилласан.<br>Баруун бүс дэх газрын даргад 7 хоног бүрийн хийсэн ажлын тайланг хугацаанд гаргаж албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 8 | Арга хэмжээ 5.2.<br>Албаны үйл ажиллагааны чиглэлээр холбогдох судалгаа, илтгэх хуудас, танилцуулга, төлөвлөгөө тайланг гарган, Газрын холбогдох нэгж, удирдлагад мэдээлэх | Боловсруулсан баримт бичгийн тоо | 100 | Холбогдох албан тушаалтанд цаг хугацаанд нь гаргаж өгсөн байна. | Тайлант хугацаанд:<br>Удирдах албан тушаалтанд илтгэх хуудас -18 удаа<br>Төлөвлөгөө -1 удаа<br>Сар бүрийн хийсэн ажлын тайлан- 11 удаа улиралын тайлан-3 удаа гаргаж Баруун бүс дэх газрын дарга болон Увс аймаг дахь хэлтсийн даргад тухай бүрд нь цахимаар хүргүүлэн ажилласан.<br>Завхан аймгийн прокурорын газраас ирүүлсэн | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан бичигт хариу илгээж ажилласан-1 удаа | | |
| 9 | Арга хэмжээ 5.3.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх | Өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлсэн тухайгаа тухайн албан тушаалтанд танилцуулж, дүгнүүлсэн байх | 100 | Үүрэг даалгаврыг хуульд тогтоомжийн дагуу биелүүлсэн байна. | Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрүүдэд Хариуцлагтай эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэж тогтоосон цагуудад холбогдож Орон нутаг дахь нөхцөл байдлын мэдээг өгч ажилласан.<br>Баруун бүс дэх газрын даргын өгсөн чиглэлийн дагуу 2024.04.05-2024.04.27-ны өдрүүдэд Баруун бүс дэх газрын даргын өгсөн чиглэлийн дагуу Арцсуурь автозамын боомтод үүрэг гүйцэтгэсэн.<br>2024 оны 05 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Баруун бүс дэх газрын дарга, хяналтын улсын ахлах байцаагчийн өгсөн чиглэлийн дагуу Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт хэлтсийн дарга хамт ажилласан.<br>2024оны 05 дугаар сарын 20-ны өдөр БНАУлсын иргэдийн амьдарч байсан Өргөө зочид буудлын өрөөг суллах ажлыг Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга Х.Бэхбат даргын өгсөн чиглэлийн дагуу буудлын өрөөг суллан буудлын эрхлэгчид өрөөг хүлээлгэн өгч ажилласан.<br>2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр БНАУлсын иргэдийн амьдарч байсан Өргөө зочид буудлын гражид байсан эд зүйлсийг Улаанбатар хотод хүргэх ажлыг зохион бичлэг болон зургаар баримтжуулан ажилласан.<br>2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Хэлтсийн даргын №4 Чиглэл зөвлөмж хүргүүлэх тухай дотоод албан бичгтэй уншиж танилцан албандаа хэрэгжүүлж ажиллаж байна.<br>Баруун бүс дэх газрын Хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу 2024.07.10-15-ны өдрүүдэд хариуцсан аймаг орон нутгийн нөхцөл байдлын мэдээг тогтоосон цагуудад өгч ажилласан.<br>Удирдлагын академийн “Богино хугацааны сургалтын хэрэгцээг тодорхойлох” судалгаанд цахимаар хамрагдсан.<br>Баруун бүс дэх газрын даргын өгсөн чиглэлийн дагуу Арцсуурь авто замын боомтод 2024.10.17-2024.10.29-ний өдрийг дуустал | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан. | | |
| 10 | Арга хэмжээ 5.4.<br>Аймаг орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудаас болон байгууллагын хэмжээнд зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд оролцох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах | Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байх | 100 | Сургалт, олон нийтийг хамарсан ажилд санаачлага гарган оролцох | Арцсуурь боомтын шинээр баригдах цогцолборын ажилд Дукат ХХК-д саналаа өгч ажилласан.<br>2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Завхан аймгийн хэмжээнд бүх нийтийн цас мөс цэвэрлэх ажилд оролцсон.<br>2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Арцсуурь авто замын боомтын зөвлөлийн хуралд оролцсон.<br>2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр байгууллагын ойр орчмын цас мөс цэвэрлэх ажилд оролцсон.<br>Завхан аймгийн прокурорын газраас Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэлийн дэвтэрийг шалгаж, шинэчлэн гаргах талаар зөвлөгөө өгч заавартын дагуу шинэчлэн гаргасан.<br>2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулилт"-д оролцсон.<br>2024 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга [illegible] байгууллагуудын удирдах албан тушаалтнуудтай хийсэн мэдээ мэдээллийн хуралд оролцсон.<br>2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга [illegible] төрийн албан хаагчидтай хийсэн уулзалтад хамрагдсан.<br>2024.09.23-ны өдөр УИХ-ын дарга [illegible] Завхан аймагт ирж иргэдтэй уулзах уулзалтад оролцсон. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 11 | Арга хэмжээ 5.5.<br>Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хийж, албан хэрэгцээнд ашиглаж буй эд хогшил, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж, засаж сайжруулах арга хэмжээ авах | Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах | 100 | Тооллого судалгааг үнэн зөв хөтлөж гаргасан байна. | Өөрийн хариуцсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.<br>2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр албанд хэрэглэгдэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын тулгалт бүртгэлийг хийж баруун бүс дэх газрын нярав цахимаар хүргүүлэн ажилласан,<br>Завхан аймаг дахь албаны өрөөний ширээ эвдэрсэн бөгөөд засаж сайжруулан ашиглан хэрэглэж байна. | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Арга хэмжээ 5.6.<br>Ажлын чиг үүргийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, удирдлагад танилцуулж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, зөвлөгөө, мэдээлэл хүргэж ажиллах | Иргэн аж ахуй нэгж, байгууллагаас төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх | 100 | Ирүүлсэн өргөдөл, гомдлийн бүсийн захиргаанд шилжүүлж ажиллах. | 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр иргэнээс ирүүлсэн мэдээллийн дагуу Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг ББ-2024/14-04 удирдамжийн дагуу Завхан аймгийн Улиастай сумын ХХК-Д хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд БНХАУ-ын 8 иргэнд торгуулийн арга хэмжээ авч албадан гаргах ажиллагаа явуулсан ажилласан.<br>2024 оны 10 дугаар сарын 28-ний өдөр иргэнээс ирүүлсэн мэдээллийн дагуу Төлөвлөгөөт бу хяналт шалгалтыг ББ-2024/14-08 тоот удирдамжийн 2024 оны 10 дугаар сарын 30-31-болон 11 дүгээр сарын 06-ны өдрүүдэд Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Улаантолгой багт Дулааны цахилгаан станцыг барьж байгаа “ ” ХХК-д ийн объект дээр хийж гүйцэтгэсэн БНХАУ-ын 7 иргэнд торгуулийн арга хэмжээ авч БНХАУ-ын 6 иргэнийг албадан гаргах ажиллагаа явууж ажилласан болно. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 13 | Арга хэмжээ 5.7.<br>Үнэт цаасны тооцоог сар бүр гарган тайлагнах. | Шийтгэврийн хуудасны зарцуулалтын тайланг гаргасан байх. | 100 | Зарцуулалтын тооцоо сар бүр гарган санхүүд хүргүүлэн ажилласан байна. | Завхан аймгийн санхүү төрийн сангийн мэргэжилтэн Үнэт цаас хүлээн авч үнэт цаасны ашиглалт, зарцуулалтын сар бүрийн тайланг гаргаж тайлагнаж тайланг өгч ажиллаж байна.<br>Баруун бүс дэх газрын ерөнхий нягтланд ашиглалт, зарцуулалтын тайланг өгч ажиллаж байна. | 2024.01.02<br>2024.11.29 | |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин(биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.1. Архив албан хэргийн хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулахүйл ажиллагаандаа мөрдлөг болгох | Хүлээлгэн өгсөн архивын нэгжийн тоо | 100 | боловсруулсан баримт бичгийг стандартын дагуу цэгцлэн,байгууллагын архивд хүлээлгэн өгөх | 2023 онд Баруун бүсийн газраас боловсруулсан 1 архивын нэгжийг баримт бичгийн стандартын дагуу цэгцлэн байгууллагын архивд хүлээлгэн өгсөн. | 2024.01.02<br>2024.06.10 | |
| | Арга хэмжээ 1.2. Хамтран ажиллагаатай байгууллагатай төлөвлөгөө батлуулах | Хамтран ажиллах нөхцөл бүрднэ | 100 | Хамтран ажиллах нөхцөл сайжирсан байна | 2024 онд Хилийн цэргийн 0277-р ангитай хамтран ажиллах төлөвлөгөөг батлуулан Баруун бүс дэх газарт шуудангаар хүргүүлэн ажилласан. | 2024.01.02<br>2024.06.10 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 1.3. Төвөөс болон орон нутгаас ирүүлж буй судалгаанд хамрагдах | Судалгааг тухай бүрд нь үнэн зөв бөглөх | 100 | Судалгаанд тухай бүр хамрагдаж ажилласан байх | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан байгууллагын Ёс зүйн дэд хороог байгуулахад хорооны гишүүдэд саналаа өгсөн. Байгууллагын орон сууцны судалгаа, амьжиргааны түвшингийн судалгаа, сургалтын оролцоог тодорхойлох, төрийн албан хаагчдад зориулсан судалгаа, авлигыг мэдээлэх системийг сайжруулах судалгаа, ГИХГ-ын цахим шилжилтийн үр нөлөөтэй байдлын судалгаа, өөрчлөлт шинэчлэлтэд бэлэн байдлын судалгаа, албан хаагчдын дүрэмт хувцасны загвар, төрөл, зориулалт, иж бүрдэл, ялгах тэмдэг, эдэлгээний хугацаанд өөрчлөлт оруулах, Нийгмийн баталгаа болон сургалтын төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид цол олгох журам"-ын цолны загварын санал асуулга, Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх асууж судалгаанд хамрагдсан. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 3 | Арга хэмжээ 1.4.<br>Завхан аймгийн албаны өрөөнд ая тухтай орчинг бүрдүүлэх | ая тухтай орчинг бүрдүүлэх | 100 | Эрүүл аюулгүй цэвэр орчинг бүрдүүлэх | 1. Мэдээ мэдээллийн самбар хийлгэж байрлуулсан.<br>2. Тарьж ургуулж байгаа цэцгийн 7 савыг томруулан арчилж байна.<br>3. Албаны өрөөний хаалганы хаягийг шинэчилэн хийж байрлуулсан.<br>4. Албаны өрөөний хананд байгууллагын лого нэршил хийлгэж байршуулсан.<br>5. Албаны өрөөний цонхыг дулаалах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 4 | Арга хэмжээ 1.5.<br>Арцсуурь авто замын боомтын амьдрах байрны цэвэрлэгээг хийж, ая тухтай орчинг бүрдүүлэх | ая тухтай орчинг бүрдүүлэх | 100 | Эрүүл аюулгүй цэвэр орчинг бүрдүүлэх | Арцсуурь боомтод ажиллах хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын талаар:<br>1. Арцсуурь боомтод ажиллах хугацаандаа цэвэрлэгээ хийж будаггүй байсан паар, турба, цонхыг цагаан будаг авч будсан.<br>2. Арцсуурь боомтын өрөөнд мэдээллийн самбар, байгууллагын лого нэршилийг тогтоож байршуулсан<br>3. Албаны өрөөнд их цэвэрлэгээ арчилгаа хийж ажилласан. | 2024.01.02<br>2024.11.29 | |
| 5 | Арга хэмжээ 1.6.<br>Өдөр тутмын хөдөлгөөний мэдээ гаргах | Мэдээллийг түргэн шуурхай хүргэх | 100 | Мэдээллийг түргэн шуурхай хүргэж ажиллах | Арцсуурь авто замын боомтын зорчигчийн хөдөлгөөний өдөр тутмын мэдээг /ISM программ ажиллахгүй байгаа/ ШНАлбанаас авч өдөр бүр нэгтгэн Баруун бүс дэх газарт хүргэж ажилласан. Мөн өдөр тутмын бүртгэлийн дэвтэрээ хөтөлж, ББГ-ын газрын даргын баталсан хуваарийн дагуу 6-н боомтуудын хөдөлгөөний болон онцлог үйл ажиллагааны мэдээг Бүсийн газрын боомтуудын нэгдсэн мэдээг 4 сард 7 удаа, 7 сард 7 удаа, 8 | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сард 2 удаа нийт 16 удаа мэдээ нэгтгэж гаргаж ажилласан. | | |
| 6 | Арга хэмжээ 1.7<br>Байгууллагын үйл ажиллагааны талаар мэдлэг түгээсэн сургалт зохион байгуулсан байна. | Сургалт мэдээллийг түгээсэн байна | 100 | Сургалт мэдээллийг зохион байгуулсан байна | 2024.08.05-ны өдөр Арцсуурь авто замын боомтын Шалган нэвтрүүлэх албаны ажилтан Заставын дарга, боомтын орлогч, шалгагч болон тээврийн хэрэгслийн шалгагч гэсэн 5 ажилтанд “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт”өөр сургалт орж ажилласан. | 2024.01.02<br>2024.11.29 | |

Нэмэлт үүрэг даалгавар(арга хэмжээ)-ын биелэлт

**Хоёр. мэдлэг, чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Эхний хагас жил | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1 | Арга хэмжээ №1.1.<br>Шинээр батлагдсан эрх зүйн актуудыг судлах, төрийн болон төрийн бус байгууллагуудын зарласан сургалтуудад хамрагдах | Сургалтанд хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. | 100 | | Уншиж танилцсан үүрэг, зөвлөмж, дотоод албан бичиг-13<br>Ерөнхий газраас зохион байгуулсан Байгууллагын үйл ажиллагааны хуралд цахимаар 3 удаа хамрагдсан.<br>Ерөнхий газраас зохион байгуулсан Мэдээллийн цагт-12 удаа хамрагдсан.<br>Баруун бүс дэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан тоо: 8 удаагийн сургалтад цахимаар хамрагдсан.<br>Баруун бүс дэх газар болон хэлтсийн цахим хуралд- 5 удаа хамрагдсан.<br>Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” вебинар сургалт-9 удаа хамрагдсан.<br>Аймаг орон нутгаас зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан тоо: 3 удаа танхимаар.<br>Удирдлагын академийн монгол бичгийн анхан болон дунд шатны 80 цагийн сургалтад хамрагдж төгссөн<br>Удирдлагын академийн дунд шатны мэргэшүүлэх сургалтад 7 хоног бүрийн 4 дэх өдөр бүтэн өдрийн сургалтад хамрагдаж байна.<br>2024.11.20-ны өдөр Тагнуулын ерөнхий газраас зохион байгуулсан “Терроризмоос урьдчилан сэргийлэх” нь сэдэвт сургалтад цахимаар хамрагдсан<br>Боомтод ажилласан тухай 2024 оны 04, 07, 08, 10 дугаар саруудад боомтод ажилласан тухай баталгааг гаргаж хэлтсийн даргад хүргүүлэн ажилласан.<br>2024.10.01-2024.11.29-ний өдрүүдэд Байгууллагын цахим сүлжээнд байршуулсан мэдээллийг өөрийн цахим | 2024.01.02<br>2024.11.29 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хуудас болон Завхан аймгийн 11 мэдээллийн цахим хуудсаар 4 төрлийн мэдээ мэдээллийг давхардсан тоогоор нийт 150 удаа түгээн мэдээлэн хуваалцсан. | | |
| 2 | Арга хэмжээ №1.2. Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх | Сургалтанд хамрагдаж мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. | 100 | | Удирдлагын академын монгол бичгийн анхан шат болон дунд шатны 80 цагийн сургалтад хамрагдаж үнэмлэх авсан.<br>Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж байна. | 2023.12.10<br>2024.11.29 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Г.ХИШИГДЭЛГЭР

2024 оны 12 дугаар сарын 04 өдөр